



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 742

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3, 4.4 заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн буцалтгүй тусламжийн санхүүжилтийн хүрээнд бий болсон 28,489,705.00 (хорин найман сая дөрвөн зуун наян есөн мянга долоон зуун таван) төгрөгийн үнэ бүхий байгаль хамгаалагчийн байрыг Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Дорноговь аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон 9.500.000.00 (есөн сая таван зуун мянган) төгрөгийн үнэ бүхий усны хяналт шинжилгээний барилгыг Галба-Өөш долоодын говийн сав газрын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга С.Батмөнх, Галба-Өөш долоодын говийн сав газрын захиргааны дарга Б.Ялалтбаяр нартдор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

*Д. Нарангэрэл*

Д.НАРАНГЭРЭЛ

13201861